



ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ

1997 оны 7 дугаар сарын 5-ны өдөр
Улаанбаатар хот

Дугаар 06

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН 1997 ОНЫ 71 ДҮГЭЭР

ЗАРЛИГ МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙГ

ЗӨРЧСӨН ЭСЭХ ТУХАЙ /Дүгнэлт/

Монгол Улсын төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3-т буй "ард түмний эв нэгдэл, үндэсний аюулгүй байдлын эрх ашигт нийцүүлэн төр, сүм хийдийн болон шашин хоорондын харилцааг Монгол Улсын Ерөнхийлөгч зохицуулна" гэсэн заалтыг төрийн өмчийн эд зүйлсийг захиран зарцуулах үйл ажиллагаатай холбон үзэх үндэслэлгүй байх тул Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйл, Үндсэн хуулийн Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай Монгол Улсын хуулийн 32, 33 дугаар зүйлийг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1.Зарим сүм хийдийг сэргээн ажиллуулах тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1997 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 71 дүгээр зарлиг Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийг зөрчсөн;

2.Энэхүү дүгнэлтийг хүлээн авсанаас хойш хэрхэн шийдвэрлэсэн тухай хариуг Үндсэн хуулийн Цэцэд маргаан хянан шийдвэрлэх



ажиллагааны тухай Монгол Улсын хуульд
заасан хугацаанд ирүүлэхийг Улсын Их
хуралд уламжилсугай.

Дарга
Ж.БЯМБАЖАВ

Гишүүд
Л.БААСАН

Ж.БЯМБАА

С.ЖАНЦАН

Д.ЧИЛХААЖАВ